

## ШАР ЛУУВАН

### Ач холбогдол.



А амин дэм болон каротин ихээр агуулсан. Нүдний хараа тогтворжуулах, цус багадалтаас урьдчилан сэргийлэх, хүүхдийг хоол тэжээл, амин дэмийн дутагдлаас хамгаалах зэрэгт эмчилгээний журмаар хэрэглэдэг.


### Сорт.

Манай оронд Нантская-4, Шантена-2461 зэрэг сортыг тариалдаг. Үүнээс Нантская-4 сорт нь 1 м. кв талбайгаас 4кг ургац өгдөг. Түргэн болцтой үр цухуйснаас хойш 80-100 хоногт болц гүйцдэг. Тод улаан өнгөтэй амт чанараар илүү. Шантена-2461 сорт нь арай гонзгой хэлбэртэй, шаравтар өнгөтэй.

### Ургах нөхцөл.


Үр нь 2-3 °С-д ургаж эхлэх боловч 20 °С –д түргэн соёолж эрчимтэй ургадаг. Үрийг хөрсөнд суулгаснаас хойш 8-14 хоноод соёолдог. Соёолж гарч ирсэн үрийн тал нь -3-4 хэмийн хүйтнийг тэсвэрлэх чадвартай. Элсэнцэр, хөнгөн шавранцар хөрсөнд сайн ургана.

### Ээлжлэн тариалалт.



**Хөрс боловсруулалт.** Хүнд шавранцар хөрсөнд түүний үндэс үр нь чөлөөтэй томорч чадахгүйгээс салаалж буруу хэлбэртэй ургана Лууван тарих хөрсийг намар эсвэл хавар эрт цэнэг усалгаа хийсний дараа 25-30см гүн хагалж боловсуулаад сайн тэгшилнэ.

### Үрийг тарилтанд бэлтгэх.



Шар луувангийн үрийн хальс нь эфирийн тос агуулсан байдаг учир дэвтэж соёолтолоо удаан хугацаа шаарддаг. Иймд үрийг 5%-ийн давсны уусмалд хийж 3-5 хоног дэвтээсний дараа хөрсөнд суулгана. Үр дэвтээсэн усыг өдөрт 2 удаа солино. Усыг солихгүй бол үр нь түүний хальснаас ялгарсан янтарын хүчилд түлэгдэж соёолох чадвараа алддаг.

### Тарилт.

Говийн бүсэд 4-р сарын 20-ноос 5-р сарын эхний 10 хоногт багтаан тарина. Тарихын өмнөх цэнэг усалгааг хөрс 50 см нортол хийнэ.

	<p>Үрийг туузлах аргаар тууз хооронд 40-50см, туузны мөр хооронд 18-20 см, үр хооронд 3-4 см тарьж үрийг 2-3см гүнд суулгана. Ингэж тариалаад арчилгааны технологийг зөв баримталсан нөхцөлд 10м<sup>2</sup> талбайгаас 35-40 кг ургац авах боломжтой</p>
--	---

**Арчилгаа.** Арчилгаанд услах, мөр хоорондын сийрүүлэлт хийх, хог ургамлыг устгах, ургамлыг цөөлөх, бордох ажлууд орно. Ургалтын хугацаанд 3-5 удаа услана. Нэг удаагийн усалгааг хийхдээ 1 м. кв талбайг 40-50 л усаар услана

	<p>Усалгаа бүрийн дараа сийрүүлнэ. Энэ нь хог ургамал устгах, хөрсний агааржилтыг сайжруулах, үндэс үрийг томруулах, хөрсний чийгийн алдагдлыг багасгах, усалгаагаар өгсөн ус ба хур борооны усны ашиглалтыг сайжруулах зэрэг олон ач холбогдолтой.</p>
	<p>Хөрсийг суллах үед хог ургамал үндсээрээ устдаг тул дахин сэргэж ургадаггүй.</p>
	<p>2 дахь усалгаанаас эхлэн нэмэлт бордоо хэрэглэх ба үүнд бууц ба шувууны сангасны шингэнийг ашиглана. Үүнийг бэлтгэхдээ 100л усанд 20кг бууц ба сангас хийж 3-7 хоног эсгээд түүнийгээ 10 дахин шингэлж бордсоны дараа шууд услана.</p>
	<p>Ургалтын хугацаанд 2 удаа цөөлнө. Цөөлсөнөөр цаана нь үлдэж байгаа үндэс үр / шар лууван/ эрчимтэй томроно. 1-р цөөлөлтийг жинэхэнэ навч гарах үед 2-3 см зайтайгаар, 2-р цөөлөлтийг үндэс үр үүсэх үед 5-8см зайтайгаар тус тус хийнэ. Цөөлөлтийг хийхдээ үлдэж буй ургамлыг хөдөлгөхгүй байхад анхаарна. Цөөлөлт хийхийн өмнө ба цөөлөлт хийнгүүт заавал усалгаа хийнэ.</p>

**Хураалт, хадгалалт.** 1м.кв талбайгаас 4кг ургац авна. Шар лууванг 2,5 см голчтой болсон үед 7-р сарын 15-наас хойш түүвэрлэн хураана. Х/10ны дотор луувангийн үндэс үр нь бүрэн томорсон үед хураах ба хураалтаас 7-10 хоногийн өмнө талбайг бүрэн услана. Энэ нь хураалтын дараа үндэс үр зөөлрөхгүй сайн хадгалагдах нөхцөлийг бүрдүүлнэ. Хураах үедээ үндэс үрийг гэмтээхгүйн тулд сэрээгээр хөрсийг зөөллөсөний дараа ишнээс нь татаж сугална. Сугалж авсан луувангийн ишийг 2-3 см урттай тайрч 0-1 хэмийн дулаантай 90-95 хувийн харьцангуй чийгтэй зооринд элсэлж хадгална. Зоорьгүй нөхцөлд нимгэн зүсээд хэцэлж хатаасны дараа даавуун уутанд савалж хадгална.